

Э-Сонин

23 дахь дугаар

2014 он 9 сар

Мэдээний Тойм



ҮЦТТХТ-ИЙГ ӨӨРЧЛӨН ЗОХИОН
БАЙГУУЛНА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНООС ГАРГАСАН
ШИЙДВЭРҮҮД



2013-2014 ОНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ
БУУРУУЛЛАА

ЛОНДОН ХОТНОО “МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ӨДӨРЛӨГ” АМЖИЛТТАЙ ЗОХИОН
ЯВАГДЛАА



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
БОЛОН FTSE ГРУППИЙН
ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА
ДАХИН СЭРГЭЛЭЭ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСЫГ
БЛҮҮМБЕРГЭЭР ДАМЖУУЛАН
АРИЛЖААЛАХААР БОЛЛОО



“I LIKE MONGOLIAN CAPITAL MAR-
KET” АРГА ХЭМЖЭЭНД МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭМЖИГЧ
БАЙГУУЛЛАГААР ОРОЛЦЛОО

“ИНВЕСТ МОНГОЛИА-2014” ЧУУЛГАНД ХӨРӨНГИЙН
БИРЖ АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Үйл явдлын хураангуй

- Үнэт цаасны зах зээлийн орон тооны бус бодлогын зөвлөл байгуулагдлаа
- Засгийн газрын өрийн хэрэгслэлийг бүртгэлээс хаслаа
- Засгийн газрын үнэт цаасыг Блүүмбергээр дамжуулан арилжаалхаар боллоо
- “Инвест Монголиа-2014” чуулганд Монголын хөрөнгийн бирж амжилттай оролцлоо
- Олон улсын валютын сангийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав
- Сангийн яамнаас Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан ирүүллээ
- Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хамтран ажиллах саналыг Европын сэргээн босголт хөгжлийн банкинд хүргүүллээ
- Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран Кастодианы ээлжит сургалтыг амжилттай зохион явууллаа

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 9-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт 10 дугаар сарын 27-ны өдөр эхэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг Утас: 11-313747 /116 дугаараас авна уу.



ҮЦТТТХТ-ИЙГ ӨӨРЧЛӨН ЗОХИОН БАЙГУУЛНА

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 292 дугаар тогтоолоор ҮЦТТТХТ-ийн бүтцийг өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд үүний хүрээнд МХБ нь үнэт цаасны арилжааны тооцооны болон төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын хувьцааг 100 хувь эзэмшинэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОН ТООНЫ БУС БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАГДЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 237 дугаар тушаалаар “Үнэт цаасны зах зээлийн орон тооны бус бодлогын зөвлөл” байгуулагдлаа. Уг зөвлөл нь үнэт цаасны зах зээлийн хөгжил, бодлого, зохицуулалтын болон салбарт тулгамдсан асуудлуудыг хэлэлцэхээс гадна үнэт цаасны зах зээлийн цаашдын хандлага, хэтийн төлөв байдал зэрэг бодлогын асуудлаар хэлэлцэж санал, дүгнэлт гаргаж ажиллана. Бодлогын зөвлөл нь Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Монголбанк, “МХБ” ТӨХК, “ҮЦТТТХТ” ХХК, Компанийн засаглалын хөгжлийн төв, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Санхүүгийн зах зээлийн холбооны төлөөлөл болон их, дээд сургуулийн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОВ

1. “Юу Би Би Ди” ХХК
2. “Өү Си Би” ХХК
3. “Марс капитал” ХХК
4. “Орчлон оюу” ХХК
5. “Трейшурь капитал” ХХК
6. “Гэгээн секьюритиз” ХХК
7. “Глобаль траст секьюритис” ХХК
8. “Зууны гарц секьюритиес” ХХК
9. “Соёмбо инвестмент” ХХК
10. “Скайхан капитал” ХХК
11. “Чоно капитал” ХХК
12. “Очир-Эрдэнэ инвест” ХХК
13. “Грийт секьюритис” ХХК -иудын Үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

“Өгөөмөр Уул” ХК-ийн үнэт цаасыг бүртгэлээс хаслаа.

2013-2014 ОНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ БУУРУУЛЛАА

Монголын хөрөнгийн бирж нь гишүүн Брокер, дилерийн компаниудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос гаргасан санал, хүсэлтийг харгалзан гишүүнчлэлийн жилийн хураамжийн хэмжээг бууруулах шийдвэр гаргалаа. Гишүүнчлэлийн жилийн хураамжийн хэмжээ 2.5-3.5 сая төгрөг байсныг 1.5 сая төгрөг болгон бууруулж, арилжааны системд нэвтрэх эрх буюу терминал ашиглах төлбөр /нэг сарын 195,000 төгрөг, жилийн 2.3 сая төгрөг/-ийг 2014 он дуустал бүрэн чөлөөлөхөөр болсон бөгөөд ийнхүү хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлснээр нэг гишүүн компанид нийтдээ 8 орчим сая төгрөгийн хэмнэлт гарах юм.




МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БОЛОН FTSE ГРУППИЙН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ДАХИН СЭРГЭЛЭЭ

Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн “FTSE групп”-ийн Засаглал, бодлого хариуцсан захирал Крис Вүүдсээс 2014 оны 9-р сарын 17-ны өдөр “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д албан бичиг ирүүллээ. Уг албан бичигт FTSE группийн Засаглалын зөвлөлийн хурал 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр болж Монголын хөрөнгийн зах зээлийг “Frontier” хөгжиж буй зэрэглэлийн “Ажиглалтын жагсаалт”-д үлдээн 2015 оны 9 дүгээр сард болох дараагийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасныг мэдэгдэж, Монголын хөрөнгийн бирж болон FTSE группийн хамтын ажиллагаа сэргэж буйд талархалаа илэрхийллээ. “FTSE групп” нь Их Британийн нийслэл Лондон хотноо байрладаг бөгөөд олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгаагаар тэргүүлэгч компани юм. Дэлхийн 80 гаруй улсын хөрөнгийн зах зээлийн 120.000 гаруй индексийг арилжааны явцад шууд болон арилжааны эцэст тооцоолж гарган, зах зээлд мэдээлдэг байгууллага билээ.

ЛОНДОН ХОТНОО “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨРЛӨГ” АМЖИЛТТАЙ ЗОХИОН ЯВАГДЛАА

Монголын Хөрөнгийн бирж, Лондонгийн Хөрөнгийн биржтэй хамтран “Монголын хөрөнгийн зах зээлийн өдөрлөг”-ийг Лондон хотноо 2014 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр амжилттай зохион явууллаа. Тус арга

хэмжээнд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд Ч.Улаанаар ахлуулсан төлөөлөгчид оролцсон. Арга хэмжээний хүрээнд Лондонгийн Хөрөнгийн биржтэй 2011 онд байгуулсан стратегийн хамтын ажиллагааны гэрээг хэлэлцээний үр дүнд хүрсэн нөхцөлөөр 3 жилээр сунгах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Мөн гадаадын хөрөнгө оруулагчидтай дугуй



ширээний уулзалтыг зохион байгуулж, Монгол Улсад оруулж буй гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас баримтлаж буй бодлого чиглэл, Монголын хөрөнгийн биржийн явуулж буй үйл ажиллагааг сурталчилан танилцууллаа.



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаагаар арилжигдаж үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдсөн Монгол Улсын Сангийн яамнаас гаргасан 1032 кодтой 15,210 ширхэг Засгийн газрын өрийн хэрэгслийг “Монголын Хөрөнгийн Бирж”-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 136 тоот тушаалаар, 1035 кодтой 19,970 ширхэг, 1087 кодтой 4,790 ширхэг, 1089 кодтой 30 ширхэг Засгийн газрын өрийн хэрэгслийг “Монголын Хөрөнгийн Бирж”-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 142 тоот тушаалаар үнэт цаасны бүртгэлээс хаслаа.



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСЫГ БЛҮҮМБЕРГЭЭР ДАМЖУУЛАН АРИЛЖААЛАХААР БОЛЛОО

Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Блүүмбергээр дамжуулан гүйцэтгэхээр болсон ба Сангийн яам болон “Блүүмберг” ХХК нь харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурснаар энэхүү ажлыг эхлүүлээд байна. Сангийн яамны зүгээс тус зах зээлийн хөрвөх чадвар, ил тод байдал, дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулагчдыг татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Засгийн газрын үнэт цаасны арилжааг 2014 оны 4 дүгээр улиралд багтаан Блүүмбергийн арилжааны системээр гүйцэтгэхээр боллоо.

“ИНВЕСТ МОНГОЛИА-2014” ЧУУЛГАНД ХӨРӨНГИЙН БИРЖ АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Инвест Монголиа-2014” чуулга уулзалт 2014 оны 9 дүгээр сарын 2-ноос 3-ны хооронд болсон. Энэхүү чуулга уулзалтанд гадаадын 10 гаруй орны хөрөнгө оруулагчид, Монголд үйл ажиллагаа явуулж буй банк санхүүгийн



байгууллага, хувийн хэвшлийнхэн нийт 500 орчим төлөөлөгчид оролцож, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын асуудлаар хэлэлцсэн. Тус арга хэмжээнд Монголын хөрөнгийн бирж нь өөрийн компанийн үндсэн үйл ажиллагааны талаар мэдээллэж, хөрөнгө оруулагчдад үнэт цаас хэрхэн гаргах, үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч, тухайн өдрийн арилжааны мэдээг сонирхсон иргэдэд цахим хэлбэрээр шууд танилцуулж, зааварчилгаа, зөвлөгөөг өгч ажилласан. Мөн “Монголын Хөрөнгийн Бирж”-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар салбар хэлэлцүүлэгт оролцож, Монголын хөрөнгийн биржийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлага, явуулж буй бодлого, хөрөнгө оруулах боломжуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч тус арга хэмжээнд амжилттай оролцлоо.



**“I LIKE MONGOLIAN CAPITAL MARKET”
АРГА ХЭМЖЭЭНД МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭМЖИГЧ
БАЙГУУЛЛАГААР ОРОЛЦЛОО**

“I LIKE MONGOLIAN CAPITAL MARKET” арга хэмжээнд Монголын Хөрөнгийн Бирж дэмжигч байгууллагаар оролцсон. Иргэдийг үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, идэвхтэй хариуцлагатай үнэт цаас эзэмшигч болгох, нийгмийн баялагаас шударгаар хувь хүртэх, хөрөнгийн зах зээл дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “БИ ДИ СЕК” ҮЦХКомпани санаачлан 2014 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр тус арга хэмжээг зохион явуулсан. Арга хэмжээнд 1000 гаруй хүн хүрэлцэн ирсэн бөгөөд залуу эрдэмтэн, мэргэжилтэн, салбарын удирдлагууд хөрөнгийн зах зээлийн талаарх анхан шатны мэдлэг мэдээллийг үнэт цаасны зах зээл сонирхогч ард иргэд, оюутан залуучуудад олгосон бол “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар “Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлэх хөтөлбөр, зорилго” сэдвээр, “Биржийн арилжааны программ, туршилтаар арилжаа хийх ажиллагаа” сэдвээр Дэд захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Чингүнжав нар дэлгэрэнгүй илтгэл тавьж, компанийн үндсэн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, мэргэжилтнүүд сурталчилгаа, зааварчилгаа, зөвлөгөө өгч ажилласан.

**АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ ОЛГОХ
СУРГАЛТ**



Монголын хөрөнгийн биржийн Сургалтын төвөөс хөрөнгийн зах зээл, үнэт цаасны арилжааг сонирхогч иргэдэд зориулсан “Үнэт цаасны анхан шатны мэдлэг олгох” сургалт 2014 оны 9 дүгээр сарын 22-ноос 26-ны хооронд амжилттай явагдаж төгсөлтөө хийлээ. Сургалтанд хамрагдаж, шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн 24 суралцагчдад Зах зээлийн хөгжлийн газрын дарга Ж.Мягмарсүрэн баяр хүргэж, сертификат гардуулан өглөө.



САНГИЙН ЯАМ

САНГИЙН ЯАМНААС МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАНГ ИРҮҮЛЛЭЭ

Сангийн сайдын 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Сангийн Яамнаас Дотоод аудитын ажлын хэсэг томилогдож “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн 2012-2014 оны үйл ажиллагаанд дотоод аудитыг хийсэн ба хийсэн ажлын тайлан, зөвлөмжийг 2014 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр биржид ирүүлсэн. Энэхүү дотоод аудитын шалгалтаар 2012-2013 оны үйл ажиллагаанд 16 зөрчилтэй асуудал илэрч, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад 13 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнд, байгууллагын зорилтот үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байхад эрх бүхий албан тушаалтнууд зохих зөвшөөрөлгүй шагнал урамшуулал, албан томилолтын зардлыг хэтрүүлэн гаргаж, гадаад томилолтын гүйцэтгэл үр дүнг тайлагнаагүй, хөндлөнгийн аудитын байгууллагын өмнөх онуудад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гэж дүгнэсэн байна. Түүнчлэн бүртгэлийн анхан шатны баримтаар нотлогдоогүй, хувийн хэрэгцээнд зарцуулсан зардлыг буцаан төлүүлэх арга хэмжээ авахыг зөвлөлөө.



Custody training

ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН КАСТОДИАНЫ ЭЭЛЖИТ СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН ЯВУУЛЛАА

Кастодианы үйл ажиллагааг дотоодын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх зорилгоор банкны мэргэжилтнүүдэд тусгайлан зориулсан Кастодианы үйл ажиллагааны ахисан шатны ээлжит сургалтыг 2014 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр амжилттай зохион явууллаа. Сургалтыг Лондонгийн хөрөнгийн бирж группийн ахлах зөвлөх Брюс Лоренс удирдан явуулсан бөгөөд Компанийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа (Corporate actions)-ны талаар дэлгэрэнгүй мэдээллийг өглөө. Дашрамд дурьдахад өмнөх сургалтаар Кастодианы үйл ажиллагааг Монгол Улсад эрхлэн явуулахад тулгарч болох аливаа эрсдэл, хүндрэл бэрхшээлүүд, олон улсын хөрөнгө оруулагчдын зүгээс бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих нөхцөл, шаардлагын талаар мэдээллийг олгосон.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ХАМТРАН АЖИЛЛАХ САНАЛЫГ ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКИНД ХҮРГҮҮЛЛЭЭ

2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны суурин төлөөлөгч ноён Маттью Ле Блантай уулзаж, Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хамтран ажиллахыг хүссэн Монголын талын албан бичгийг гардуулан өглөө. 64 улсын гишүүнчлэлээс бүрдэх энэхүү Олон улсын хөгжлийн банктai Монгол Улсын Сангийн яам болон Монголбанк нь 2013 онд “Дотоодын валютаар зээл олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд энэхүү хөтөлбөрт Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх болон үүнийг хэрэгжүүлэхэд тус банкны оролцох эрх үүрэг тусгагдсан байна. Тиймээс дээрх зорилтыг бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлэх саналыг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монголын талын Захирагч, Сангийн сайд Ч. Улаанаас тус банкны Ерөнхийлөгч Сэр Сума Чакрабартид хандаж албан хүсэлт гаргасныг хүргүүлээ.



ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар 2014 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Олон улсын валютын сангийн төлөөлөгчдийг өөрсдийнх нь хүсэлтийн дагуу хүлээн авч уулзав. Тус уулзалтын үеэр Монголын хөрөнгийн биржийн явуулж буй үйл ажиллагаа, бүртгэлтэй компаниуд, шинэчлэн батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн хүрээнд зах зээлд нэвтрүүлэх шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, Засгийн газрын үнэт цаасны арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулах талаар нилээд өргөн цар хүрээний мэдээ, мэдээллийг өгч, тэдгээрт хэрхэн хөрөнгө оруулж болох талаар ярилцаж, санал бодлоо солилцсон.



2014 оны 9 дүгээр сар


Арилжааны товч мэдээ

| | |
|-----------------------------|-------------------|
| Арилжигдсан ширхэг | 3,850,955 |
| Нийт үнийн дүн /төг/ | 2,268,786,434.60 |
| Хэлцлийн тоо | 891 |
| Арилжигдсан үнэт цаасны тоо | 77 |
| Зах зээлийн үнэлгээ /төг/ | 1,585,243,789,997 |

ТОП-20 индекс

| | |
|---------------------|-----------|
| Хаалт | 15,797.75 |
| Өмнөх сарын хаалт | 15,896.09 |
| Өөрчлөлт /нэгж/ | -98.34 |
| Өөрчлөлт /%/ | -0.62 |
| 52 долоо хоног дээд | 17,160.49 |
| доод | 13,422.43 |

ТОП 20 ИНДЕКС



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:

Үнийн дүнгээр:

| № | Симбол | Үнэт цаасны нэр | Арилжсан ширхэг | Үнийн дүн | № | Симбол | Үнэт цаасны нэр | Арилжсан ширхэг | Үнийн дүн |
|---|--------|-------------------|-----------------|---------------|---|--------|----------------------|-----------------|---------------|
| 1 | MSH | МОНГОЛ ШИЛТГЭЭН | 3,323,615 | 1,854,696,600 | 1 | MSH | МОНГОЛ ШИЛТГЭЭН | 3,323,615 | 1,854,696,600 |
| 2 | HRM | ГЕРМЕС ЦЕНТР | 81,558 | 13,669,496 | 2 | APU | АПУ | 19,058 | 70,982,821 |
| 3 | ETR | Э-ТРАНС ЛОЖИСТИКС | 73,676 | 6,797,037 | 3 | TTL | ТАВАН ТОЛГОЙ | 10,074 | 52,858,355 |
| 4 | JTB | ЖЕНКО ТУР БЮРО | 70,038 | 5,790,202 | 4 | AOI | АВТО ИМПЕКС | 10,614 | 41,129,420 |
| 5 | MRX | МЕРЕКС | 58,711 | 5,539,685 | 5 | BNG | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ | 416 | 24,744,000 |

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

| № | Симбол | Үнэт цаасны нэр | Өмнөх сарын хаалт | Хаалтын ханш | Ханшийн өөрчлөлт | |
|---|--------|--------------------|-------------------|--------------|------------------|-------|
| | | | | | төгрөг | % |
| 1 | SOR | СОР | 2,000.0 | 2,449.0 | 449 | 22.45 |
| 2 | ERS | МОНГОЛ АЛТ | 2,940.0 | 3,500.0 | 560 | 19.05 |
| 3 | UND | УНДРАГА-ӨМНӨГОВЬ | 5,300.0 | 6,300.0 | 1,000 | 18.87 |
| 4 | BLC | БҮТЭЭЛЧ ҮЙЛС | 795.0 | 917.0 | 122 | 15.35 |
| 5 | GFG | ГОВЬФАЙНЕНШЛ ГРУПП | 390.18 | 448.70 | 59 | 15.00 |

Хамгийн их бууралттай үнэт цаас:

| № | Симбол | Үнэт цаасны нэр | Өмнөх сарын хаалт | Хаалтын ханш | Ханшийн өөрчлөлт | |
|---|--------|---------------------|-------------------|--------------|------------------|--------|
| | | | | | төгрөг | % |
| 1 | HGL | ХАНГАЛ | 1,020.0 | 778.97 | -241 | -23.63 |
| 2 | CHR | УВС ЧАЦАРГАНА | 3,308.0 | 2,550.0 | -758 | -22.91 |
| 3 | BDL | МОГОЙН ГОЛ | 13,500.0 | 11,000.0 | -2,500 | -18.52 |
| 4 | BEU | БЭРХ-УУЛ | 4,836.0 | 4,000.0 | -836 | -17.29 |
| 5 | GTL | БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ | 4,312.0 | 3,600.0 | -712 | -16.51 |